



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансад  
бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэлтэй Нийгмийн хамгааллын төвийн /хуучин нэрээр/ байр болох нийт 589,801,240.00 (таван зуун наян есөн сая найман зуун нэг мянга хоёр зуун дөчин) төгрөгийн балансын үнэ, 98,171,916.10 (ерэн найман сая нэг зуун далан нэгэн мянга есөн зуун арван зургаан төгрөг арван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн балансад бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Ганболд, Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Норгинбадамд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001657

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 04 дүгээр сарын 24 ний өдрийн  
 144 дугаар тогтоолын хавсралт



Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газраас  
 Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст  
 балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Гарааш	2012	3,000,000.00	435,583.67	2,564,416.33
2	Нүүрсний сав	2006	617,400.00	133,770.21	483,629.79
3	Контейнер	2006	1,124,800.00	627,076.51	497,723.49
4	Нийгмийн хамгааллын төвийн байр	2005	585,059,040.00	96,975,485.71	488,083,554.29
	Дүн		589,801,240.00 (таван зуун наян есөн сая найман зуун нэг мянга хоёр зуун дөчин)	98,171,916.10 (ерэн найман сая нэг зуун далан нэгэн мянга есөн зуун арван зургаан төгрөг арван мөнгө)	491,629,323.90 (дөрвөн зуун ерэн нэгэн сая зургаан зуун хорин есөн мянга гурван зуун хорин гурван төгрөг ерэн мөнгө)